



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 03 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар *ТУЗ 2020-03/02*

Улаанбаатар
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан худалдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1, 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 62 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат комданийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Жуулчин Дюти Фрий ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.1, 7.2, 7.3 дах хэсэг, 8-р зүйлийн 8.9.3 дэх хэсгийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ нь:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04-р сарын 22-ны өдрийн Лхагва гарагийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, “Таван Богд Групп”-ийн төв байрны, 2,5-р давхарт байрлах хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

2.1 Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах,

2.2 Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах

2.3 Компанийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах,

2.4 Компанийн 2019 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах,

2.5 Компанийн 2020 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах

3. Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт №1-ээр баталж, 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хавсралт №2-оор баталж 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Монголын хөрөнгийн бирж, болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2020 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зарыг хүргэхээр тогтоосугай.

5. Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичигтэй компанийн үйл ажиллагаа хариуцсан менежер Э.Энхбаяр /Утас: 94990778, jdf-operations@tavanbogd.com/ -- тай холбогдон танилцах боломжтойг болохыг мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой бичиг баримтыг 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд болон тэдгээрт үйлчилж буй брокер, дилерийн компанид хүргүүлсүгэй.

7. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр байхаар тогтоосугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ын гишүүн Ч.Ванчин-Эрдэнийг томилсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Т.Солонго, Г.Болорцэцэг, Нягтлан бодогч Г.Энхгэрэл нарыг тус тус томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Ё.Ганбатыг томилон, хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг зөвшөөрсүгэй

11. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, хурал зорион байгуулах бэлтгэх ажлыг ханган ажиллахыг хурал зохион байгуулах комисс Гүйцэтгэх захирал Ё.Ганбат, үйл ажиллагаа хариуцсан менежер Э.Энхбаяр нарт даалгасугай.

ТУЗ-ийн дарга  Ц.БААТАРСАЙХАН



**Өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгөх
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар**



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн лхагва гарагийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Таван Богд Группийн төв байрны 2,5-р давхарт байрлах хурлын танхимд болно.

Хурлаар хэлэлцэх асуудал

- Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах
- Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах
- Компанийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах,
- Компанийн 2019 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах,
- Компанийн 2020 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 04-р сарын 3-ны өдөр байна.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй БДК-иуд болон компанийн байранд 2020 оны 3 сарын 27-ны өдрөөс ирж танилцаж боломжтой.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн байр. Ажлын өдрийн 08.00-17.00 цагийн хооронд

Утас: 95958708, 94990778 утсаар холбогдоно уу.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	"Жуулчин Дюти Фрий" ХК
Хаяг, утас	Хан-уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, "Говь" ХК-ийн байр, 3 давхарт Утас: 94990778
Хурал хуралдах өдөр, цаг	2020 оны 04 дүгээр сарын 22 -ны өдрийн 10:00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Хан-уул дүүргийн 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, "Таван Богд Групп"-ийн төв байрны 2,5-р давхарт
Хурлын төрөл:	Ээлжит хурал
Хурал зарлагч	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2020 оны 03 дугаар сарын 13 -ны өдөр
Олон нийтэд зарлах огноо	2020 оны 03 -р сарын 18-ний өдөр
Бүртгэх өдөр	2020 оны 04 -р сарын 03-ны өдөр
Хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2020 оны 03-р сарын 27-ны өдөр
Хүргүүлсэн огноо	2020 оны 03-р сарын 27-ны өдөр
Хурлын даргын нэр	ТУЗ-ийн гишүүн Ч.Ванчин-Эрдэнэ
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр	Тооллогын комиссын дарга Хуулийн зөвлөх Т.Солонго, Тооллогын комиссын гишүүд: Хуулийн мэргэжилтэн Г.Болорцэцэг, Ерөнхий нягтлан бодогч Г.Энхгэрэл.
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	1. "Жуулчин Дюти Фрий" ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2020-03-13 өдрийн тогтоол 2. ХЭ-ийн хурлын зарын загвар 3. "Жуулчин Дюти Фрий" ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлан 4. "Жуулчин Дюти Фрий" ХК-ийн 2019 оны санхүүгийн аудитлагдсан тайлан 5. Компанийн 2020 оны төсвийн санал 6. ХЭ-ийн хурлын дэг 7. ХЭ-ийн хурлын саналын хуудас 8. ХЭ-ийн хурлаас гарах шийдвэрийн төсөл
Баримт, бичгийн хуудасны тоо	 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

 /Е.Ганбат/